



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 11309

Арвайхээр сум

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн “Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг үнэлэх тухай” 17/01 дугаар хурлын тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн аялал жуулчлалын шинэчилсэн дэд хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:  
Ч.Гүнсэнхорол (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Г.Баясгалан (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Т.Ариунболд (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар)

Д.Өсөх-Эрдэнэ (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Соёл, урлагийн газрын дарга)

Ч.Бат-Өлзий (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Д.Амартувшин(аймгийн Авто тээврийн төвийн дарга)

Ц.Банди (Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга)


Д.Алтанхүү (аймгийн Аялал жуулчлалын холбооны тэргүүн) (зөвшилцсөнөөр)

Ч.Бат-Эрдэнэ(аймгийн аялал жуулчлалын холбооны гүйцэтгэх захирал) (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга: М.Мөнхсүрэн (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Дээрх аялал жуулчлалын шинэчилсэн дэд хөтөлбөрийн төслийг боловсруулж 2023 оны 06 дугаар сард багтаан Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсэг (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

A handwritten signature in black ink, appearing to read "Ишдорж".